



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга: С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер:
С.Оюунгэрэл
Утас: 260512

Аудитор: И.Туяа
Утас: 261885

Монгол Улсын Үндэсний аудитын газар

Монгол Улс
Чингэлтэй дүүрэг
Бага тойруу
Засгийн газрын IY байр

Цахим хуудас: www.audit.mn

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн
санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хавсралт 4: Жилийн төсвийн гүйцэтгэлийн
нэгтгэсэн тайлан

Оршил

Улсын Их Хурлын даргын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусгавар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна.

2013 оны төсөвт зардал 16,420.1 сая төгрөгөөр батлагдсанаас, төсвийн хуваарийн дагуу 15,025.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Олгогдсон санхүүжилтээс урсгал зардалд 13,984.6 сая, хөрөнгө оруулалтад 370.5 сая, нийт 14,355.1 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 669.9 сая төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна.

Нийт төсөвт зардлын 54.4 хувийг ажиллагчидтай холбогдсон зардал, 41 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал, 2 хувийг татаас, шилжүүлэг, 2.6 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 788.6 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 4,143.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн 56.4 хувийг компьютер, 23.2 хувийг машин, тоног төхөөрөмж, 14.3 хувийг тавилга, эд хогшил, 3.2 хувийг програм хангамж, 0.8 хувийг барилга, 2.1 хувийг номын фонд тус тус эзэлж байна.

Санхүүгийн тайланд хөрөнгө оруулалтын ажил гүйлгээ бүрэн тусгагдсан ба олгогдсон санхүүжилтийн 91.6 хувь буюу 339.6 сая төгрөгийг тоног төхөөрөмж, 8.4 хувь буюу 30.9 сая төгрөгийг тавилга, эд хогшил худалдан авахад зарцуулсан байна.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитын явцад дотоод хяналтыг үнэлэхэд: Төсвийн хөрөнгийн төлөвлөлт болон зарцуулалтад тавих хяналт хангалттай ба харин мөнгөн гүйлгээний тайланд ажил гүйлгээг дутуу тусгах, орхигдуулах эрсдэл байна.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудал хөндөгдсөн бөгөөд тэдгээрийг удирдлагын анхааралд хандуулж байна.

Төсвийн төлөвлөлтийн талаар

2013 оны төсвийн тодотголын саналыг 91 нэгжээр төсөвлөн 18,078.9 сая төгрөгөөр төсвийн хэрэгцээг тодорхойлон, Сангийн яаманд хүргүүлсэн байна. Сангийн яам 2013 оны тодотгосон төсвийг 16,420.1 сая төгрөгөөр буюу анх төсөвлөснөөс 1,658.8 сая төгрөгөөр бууруулах саналыг албан бичгээр УИХ-ын Тамгын газарт ирүүлсэн байна. Үүний дагуу 2013 оны төсөвт зардал 16,420.1 сая төгрөгөөр батлагджээ.

Хөрөнгө оруулалтын талаар

Хөрөнгө оруулалтын зардалд 453.2 сая төгрөг батлагдсанаас 370.5 сая төгрөгийн зарлага гаргасан ба 82.7 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

Бараа материалын талаар

Бараа материал оны эхэнд 408.3 сая төгрөгийн нөөцтэй ба тайлант хугацаанд 583.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэн нийлүүлж, үндсэн хөрөнгийн данснаас 4.6 сая төгрөгийн материал шилжүүлэн бүртгэж, нийт 588.4 сая төгрөгөөр нэмэгдсэн ба албан хэрэгцээнд шаардах хуудсаар 364.9 сая төгрөгийн бараа материалыг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар зарлагдсан ба оны эцэст 631.8 сая төгрөгийн бараа, материал нөөцөлсөн байна.

Нийт бараа материалын 32.8 хувийг сэлбэг хэрэгсэл, 22.1 хувийг сурталчилгааны материал, 17.5 хувийг бэлэг, дурсгалын зүйл, 12.5 хувийг аж ахуйн материал, 9.7 хувийг БҮТЭЗүйл, 5.4 хувийг бичиг хэргийн материал тус тус эзэлж байна

Үндсэн хөрөнгийн талаар

Үндсэн хөрөнгө оны эхэнд 4,443.7 сая, тайлант хугацаанд хөрөнгө оруулалтаар 396.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хорооноос буцалтгүй тусламжаар 149.6 сая төгрөгийн компьютер хандивласан, нийт 546.2 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, Төрийн өмчийн хорооны 2013 оны 3/1747 дугаартай албан бичгийг үндэслэн УИХ-ын Тамгын газрын ЕНБД-ын 2013 оны 420 дугаар захирамжаар ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 55 нэрийн 242.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эргэлтийн хөрөнгийн шинжтэй 7 нэрийн 7.6 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлсэн ба нийт 249.6 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, 596.8 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцогдсон ба оны эцэст 4,143.5 сая төгрөгийн хөрөнгөтэй байна.

Төсөвт зардлын талаар

2013 оны батлагдсан төсөвт зардал 16,420.1 сая төгрөгөөс, 14,355.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, төсөвт зардал 2,065.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: Ажиллагчидтай холбогдсон зардал 314.3 сая төгрөгөөр хэмнэсэн нь батлагдсан орон тооноос 29 орон тоо дутуу ажилласантай,

бичиг хэрэг, тээвэр шатахуун, гадаад, дотоод томилолт, гадаад зочны арга хэмжээ, мэдээлэл, сурталчилгаа болон бусад зардлуудыг 1,750.7 сая төгрөгөөр хэмнэсэн нь Засгийн газрын 2013 оны 324 дүгээр тогтоолын дагуу тайлант хугацаанд зарцуулахаар төлөвлөсөн тэвчиж болох урсгал зардлыг бууруулах, ашиглагдаагүй зардлыг хэмнэхэд анхаарч ажилласантай тус тус холбоотой байна.

Аудитаар илэрсэн бүх асуудлыг УИХ-ын Тамгын газрын удирдлага авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай ба аудитын явцад илрүүлсэн алдааг үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрч, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар тохиролцсон тул материаллаг алдаагүй гэж үзлээ.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Мөнгөн хөрөнгийн талаар

Мөнгөн хөрөнгийн тайланд 1,259.7 сая төгрөгийн ажил гүйлгээг дутуу тусгаж тайлагнасныг аудитын явцад залруулсан тул зөвлөмж өгөх шаардлагагүй гэж үзлээ.

Цаашид НББОУС 1.15-д: “Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэснийг, Мөн “Иж бүрэн байх: бүртгэгдээгүй хөрөнгө, өр төлбөр, ажил гүйлгээ, үйл явдал буюу дэлгэж харуулаагүй зүйл үгүй байх”, гэсэн батламж мэдэгдлийг тус тус баримталж ажиллах нь зүйтэй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газар аудит хийсэн ба уг аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

Бид Улсын Их хурлын даргын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Ерөнхий аудитор санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210546 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 66.9

танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ЗАНДААХҮҮГИЙН ЭНХБОЛД
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал юм.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.


Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Тамгын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын Их хурлын Тамгын газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Тамгын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

| 2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх | | <i>/төгрөгөөр/</i> | |
|---|-------------------------|-------------------------|--|
| Балансын зүйл | 2012 оны 12-р сарын 31 | 2013 оны 12-р сарын 31 | |
| Хөрөнгө | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 26,180,000.00 | 10,164.27 | |
| Авлага | 12,854,000.00 | 38,822,573.00 | |
| Урьдчилгаа | 234,000,000.00 | 117,978,962.85 | |
| Бараа материал | 408,316,433.82 | 631,772,822.02 | |
| Эргэлтийн хөрөнгийн нийт дүн | 681,350,433.82 | 788,584,522.14 | |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Биет хөрөнгө | 4,321,649,529.73 | 4,009,871,580.69 | |
| Биет бус хөрөнгө | 122,092,363.82 | 133,615,680.53 | |
| Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн | 4,443,741,893.55 | 4,143,487,261.22 | |
| Хөрөнгийн нийт дүн | 5,125,092,327.37 | 4,932,071,783.36 | |
| Өр төлбөр | | | |
| Богино хугацаат өр төлбөр | | | |
| Өглөг | 26,180,000.00 | 3,464,292.31 | |
| Урьдчилж орсон орлого | | | |
| Бусад өглөг | | | |
| Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн | 26,180,000.00 | 3,464,292.31 | |
| Цэвэр хөрөнгө | | | |
| Цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт | | | |
| Засгийн газрын байгууллагын хувь оролцоо | 3,565,448,394.84 | 3,560,849,767.86 | |
| Дахин үнэлгээний нөөц | 21,659,043.47 | 21,659,043.47 | |
| Хуримтлагдсан үр дүн | 1,511,804,889.06 | 1,346,098,679.72 | |
| Өмнөх үеийн үр дүн | | 1,511,804,889.06 | |
| Тайлант үеийн үр дүн | | (165,706,209.34) | |
| Цэвэр хөрөнгөлөмчийн нийт дүн | 5,098,912,327.37 | 4,928,607,491.05 | |
| Өр төлбөр, Цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлтийн нийт дүн | 5,125,092,327.37 | 4,932,071,783.36 | |

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

| 2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх | | <i>/төгрөгөөр/</i> | |
|--|------------------------|------------------------|---|
| Балансын зүйл | 2012 оны 12-р сарын 31 | 2013 оны 12-р сарын 31 | |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | | | |
| Татаас санхүүжилтийн орлого | 16,502,822,681.97 | 14,354,380,272.34 | |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | | | |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 167,109,718.59 | 233,542,497.53 | |
| Тусламжийн орлого | | 149,600,000.00 | |
| Үндсэн үйл ажиллагааны орлогын нийт дүн | 16,669,932,400.56 | 14,737,522,769.87 | |
| Үндсэн үйл ажиллагааны зардал | | | |
| Цалин ,хөлс болон ажиллагсдын тэтгэмж | 7,126,101,427.53 | 7,797,255,884.10 | |
| Бараа үйлчилгээний зардал | 7,921,708,590.74 | 5,365,169,189.38 | |
| Элэгдэл, хорогдлын зардал | 606,971,305.01 | 841,912,375.05 | |
| Татаас, тусламж, шилжүүлэг | 563,014,396.20 | 903,490,157.66 | |
| Үндсэн үйл ажиллагааны зарлагын нийт дүн | 16,217,795,719.48 | 14,907,827,606.19 | |
| Үндсэн үйл ажиллагааны нийт үр дүн | 452,136,681.08 | (170,304,836.32) | |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | | 4,598,626.98 | |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз | | | |
| Үндсэн хөрөнгө акталсан | | 4,598,626.98 | |
| Үндсэн бус үйл ажиллагааны зарлага | | | - |
| Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны гарз | | | |
| Тайлант үеийн үр дүн | 452,136,681.08 | (165,706,209.34) | |

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

| 2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх | | /төгрөгөөр/ |
|---|--------------------------|--------------------------|
| Үзүүлэлт | 2012 оны 12-р сарын 31 | 2013 оны 12-р сарын 31 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Хүлээн авсан мөнгөн хөрөнгө: | | |
| Татаас, санхүүжилтийн орлого | 16,502,822,681.97 | 15,024,962,830.00 |
| Нэмэлт санхүүжилт | | 206,580,600.00 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 167,109,718.59 | 233,542,497.53 |
| Бусад орлого | | 147,000.00 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн | 16,669,932,400.56 | 15,465,232,927.53 |
| Зарцуулсан мөнгөн хөрөнгө: | | |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 6,441,568,212.99 | 7,035,665,853.61 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 684,533,214.54 | 780,655,453.74 |
| Бараа үйлчилгээний зардал | 8,006,598,542.13 | 6,374,934,928.25 |
| Татаас, тусламж, шилжүүлэг | 563,014,396.20 | 903,490,157.66 |
| Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн | 15,695,714,365.86 | 15,094,746,393.26 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 974,218,034.70 | 370,486,534.27 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Биет болон биет бус хөрөнгө худалдан авсан | 1,097,891,228.00 | 396,656,370.00 |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | 1,097,891,228.00 | 396,656,370.00 |
| Гадаад валютын арилжааны (гарз)олз | | |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | -123,673,193.30 | -26,169,835.73 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 149,853,193.30 | 26,180,000.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 26,180,000.00 | 10,164.27 |

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

| 2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх | | | | \төгрөгөөр\ |
|---|---------------------------------|-----------------------|----------------------|--|
| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| 2011 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,606,921,012.84 | 21,659,043.47 | 1,059,668,207.98 | 3,688,248,264.29 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Үндсэн хөрөнгийн үнэлгээний өсөлт бууралт | 958,527,382.00 | | | 958,527,382.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | 452,136,681.08 | 452,136,681.08 |
| 2012 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 3,565,448,394.84 | 21,659,043.47 | 1,511,804,889.06 | 5,098,912,327.37 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Үндсэн хөрөнгийн үнэлгээний өсөлт бууралт | (4,598,626.98) | | | (4,598,626.98) |
| Тайлант үеийн үр дүн | | | (165,706,209.34) | (165,706,209.34) |
| 2013 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 3,560,849,767.86 | 21,659,043.47 | 1,346,098,679.72 | 4,928,607,491.05 |

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

| 2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх | | | / төгрөгөөр / | |
|--|--------------------------|--------------------------|---------------------------|--------------|
| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | | 26,180,000.00 | | |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V) | 16,420,099,100.00 | 14,355,152,169.87 | 2,064,946,930.13 | 87.4 |
| II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV) | 16,420,099,100.00 | 14,355,152,169.87 | 2,064,946,930.13 | 87.4 |
| III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 15,966,899,100.00 | 13,984,675,799.87 | (1,982,223,300.13) | 87.6 |
| Ажиллагчидтай холбогдсон зардал | 8,130,572,000.00 | 7,816,321,307.35 | (314,250,692.65) | 96.1 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6,909,397,200.00 | 6,702,420,453.61 | (206,976,746.39) | 97.0 |
| Унаа хоолны зардал | 415,442,400.00 | 333,245,400.00 | (82,197,000.00) | 80.2 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 805,732,400.00 | 780,655,453.74 | (25,076,946.26) | 96.9 |
| Бараа ажил үйлчилгээний бусад зардал | 7,360,620,500.00 | 5,879,673,035.52 | (1,480,947,464.48) | 79.9 |
| Бичиг хэргийн материал | 109,820,000.00 | 105,300,540.00 | (4,519,460.00) | 95.9 |
| Тээвэр, шатахууны зардал | 630,844,200.00 | 541,238,548.00 | (89,605,652.00) | 85.8 |
| Шуудан холбооны зардал | 319,895,000.00 | 278,504,098.17 | (41,390,901.83) | 87.1 |
| Дотоод томилолтын зардал | 1,141,868,400.00 | 754,945,685.19 | (386,922,714.81) | 66.1 |
| Гадаад томилолтын зардал | 595,000,000.00 | 445,852,333.63 | (149,147,666.37) | 74.9 |
| Ном, хэвлэлийн зардал | 89,982,500.00 | 76,554,810.00 | (13,427,690.00) | 85.1 |
| Урсгал засварын зардал | 118,500,000.00 | 38,436,224.00 | (80,063,776.00) | 32.4 |
| Төлбөр хураамж бусад | 208,388,100.00 | 135,231,799.08 | (73,156,300.92) | 64.9 |
| Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал | 20,500,000.00 | 14,708,970.00 | (5,791,030.00) | 71.8 |
| Гадаад зочны зардал | 503,775,300.00 | 389,845,147.84 | (113,930,152.16) | 77.4 |
| Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс | 133,969,300.00 | 128,559,822.60 | (5,409,477.40) | 96.0 |
| Мэдээлэл сурталчилгааны зардал | 3,187,877,700.00 | 2,622,847,132.81 | (565,030,567.19) | 82.3 |
| Сургалт, семинар зохион байгуулах зардал | 300,200,000.00 | 347,647,924.20 | 47,447,924.20 | 115.8 |
| Татаас, шилжүүлгийн зардал | 475,706,600.00 | 288,681,457.00 | (187,025,143.00) | 60.7 |
| Шагнал урамшил | 18,000,000.00 | 14,781,590.00 | (3,218,410.00) | 82.1 |
| Олон улсын байгууллагын гишүүний татвар | 33,167,600.00 | 30,727,580.00 | (2,440,020.00) | 92.6 |
| Нэг удаагийн тэтгэмж. | 238,464,000.00 | 190,372,287.00 | (48,091,713.00) | 79.8 |
| Хуульд заасан үндэслэлээр | 100,000,000.00 | 30,000,000.00 | (70,000,000.00) | 30.0 |
| Ээлжийн амралтаараа орон нутагт явах зардал | 1,575,000.00 | - | (1,575,000.00) | 0.0 |
| Төлбөр хураамж бусад /Амь даатгал/ | 84,500,000.00 | 22,800,000.00 | (61,700,000.00) | 27.0 |
| IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 453,200,000.00 | 370,476,370.00 | (56,543,630.00) | 81.7 |

| | | | | |
|--|--------------------------|--------------------------|---------------------------|--------------|
| 1. Дотоод хөрөнгө оруулалт | 453,200,000.00 | 370,476,370.00 | (56,543,630.00) | 81.7 |
| Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж | 453,200,000.00 | 370,476,370.00 | (82,723,630.00) | 81.7 |
| VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | | | |
| | 16,420,099,100.00 | 14,355,162,169.87 | (2,064,936,930.13) | 87.4 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000,000.00 | 233,542,497.53 | 133,542,497.53 | 233.5 |
| Төсвөөс санхүүжих | 15,866,899,100.00 | 13,751,143,302.34 | (2,115,755,797.66) | 86.7 |
| Төсвөөс санхүүжих | 453,200,000.00 | 370,476,370.00 | (82,723,630.00) | 81.7 |
| Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл | | 10,164.27 | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт | | 26,179,835.73 | | |
| Байгууллагын тоо | 1 | 1 | | |
| Ажиллагчид бүгд | 624 | 595 | | |
| Удирдах ажилтан | 92 | 92 | | |
| Гүйцэтгэх ажилтан | 506 | 477 | | |
| Үйлчлэх ажилтан | 26 | 26 | | |